



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 10 нэрийн 780,312,150.00 (долоон зуун наян сая гурван зуун арван хоёр мянга нэг зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 243,400,000.00 (хоёр зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 7 дүгээр сарын 08-ны өдрийн
482 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шилжүүлэх хуулийн этгээд	Шилжүүлэн авах хуулийн этгээд
					Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)			
1	Лексус-570, 98-68 УНУ	2007	1	162,735,000.00	1	48,800,000.00	48,800,000.00	3	Хорих ял эдлүүлэх алба	409 дүгээр хаалттай хорих анги
	Дүн		1	162,735,000.00	1	48,800,000.00	48,800,000.00			
2	Соната-6, 65-02 УНС	2007	1	28,583,400.00	1	6,000,000.00	6,000,000.00	2		Цагдан хорих 461-р анги
3	Ландкрудер-200, 04-35 УНУ	2010	1	107,900,000.00	1	54,000,000.00	54,000,000.00	5		Хорих 429-р анги
4	Лексус LX470, 05-56 УНЗ	2007	1	159,243,750.00	1	35,000,000.00	35,000,000.00	4	Төв аппарат	Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар
	Дүн		1	295,727,150.00	4	95,000,000.00	95,000,000.00			
5	Киа карнивал УНВ 03-51 УНВ	2013	1	35,000,000.00	1	17,500,000.00	17,500,000.00	3	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Замын-Үүд шийдвэр гүйцэтгэх хэлтэс

6	Киа карнивал УНВ 03-61 УНВ	2013	1	35,000,000.00	1	17,500,000.00	17,500,000.00	3	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Налайх шийдвэр гүйцэтгэх хэлтэс
	Дүн		1	70,000,000.00	2	35,000,000.00	35,000,000.00			
7	Автобус /FAW/ 85-94 УНВ	2013	1	58,000,000.00	1	10,000,000.00	10,000,000.00	1	421 дүгээр нээлттэй хорих анги	415 дугаар хаалттай хорих анги
	Дүн		1	58,000,000.00	1	10,000,000.0	10,000,000.0			
8	Экскаватор 80-12 УБ		1	60,850,000.00	1	12,000,000.00	12,000,000.00	2	Хэрэмт цамхаг УТУГ	Үйлдвэр, аж ахуйн барилгын хэсэг
9	Хьюндай маяти, 81-33 УНЗ	2008	1	16,000,000.00	1	3,600,000.00	3,600,000.00	2		415 дугаар хаалттай хорих анги
	Дүн		1	76,850,000.00	2	15,600,000.00	15,600,000.00			
10	Ландкрудер-78, 04-61 УНЗ	2014	1	117,000,000.00	1	39,000,000.00	39,000,000.00	2	Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги	409 дүгээр хаалттай хорих анги
	Дүн		1	117,000,000.00	1	39,000,000.00	39,000,000.00			
	Нийт дүн			780,312,150.00 (долоон зуун наян сая гурван зуун арван хоёр мянга нэг зуун тавин)		243,400,000.00 (хоёр зуун дөчин гурван сая дөрвөн зуун мянган)				